

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧАДАВХЫГ ҮНЭЛЭХ СУДАЛГАА

: Уг судалгаагаар эмнэлгийн мэргэжилтнүүдийн УӨА-ийн талаарх ойлголт, мэдлэг болон хүний эрүүл мэнд болон эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой эрсдэлүүдийн талаарх ойлголт, хандлага, УАӨ-тэй холбоотой сорилтуудыг даван туулах тэсвэртэй байдлыг үнэлсэн . Ийнхүү үнэлэхдээ нийт 32 асуулт бүхий тоон асуумж ашигласан. Эрүүл мэндийн салбарын УАӨ-д тэсвэртэй байдлыг сайжруулахад шаардлагатай арга хэмжээг тодорхойлохын тулд эрт зарлан мэдээлэл тогтолцоо болон өнгөрсөн хугацаанд байгаль, цаг уурын шалтгаантай гамшгуудын үед авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн ажилтнуудын гүйцэтгэж буй үүрэг, дадал, туршлага зэргийг тодруулан, цогцоор нь үнэлсэн судалгааг IRIM байгууллагатай хамтран 2024 оын 1 сард эхлэн 2024 оны 11 сарл хийж дуусгасан. Уг судалгааны түүврийн хэмжээг тооцоолохдоо Монгол Улсын эрүүл мэндийн салбарын нийт ажиллах хүчний тоог харгалзан үзсэн. 2022 оны байдлаар эрүүл мэндийн салбарт 63340 ажилтантай үүнээс эмч 13983, сувилагч 13947, эрүүл мэндийн салбарын удирдах ажилтан 1479 байна. Бид судалгаандаа зөвхөн эмч, сувилагч, удирдах түвшний ажилчдыг хамруулах бөгөөд судалгааны түүврийн эх олонлогийг нийт 29,409 хэмээн тооцоолж судалгаанд нийтдээ 1200 эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан .